

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /2021 ОН/

2021.12.14

Өвт

Зорилт, арга хэмжээ	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2021 он		Хэрэгжилтийн хувь
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	8
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД								
Зорилт 1: Сумын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, иргэдийн амьжиргаатай уялдуулан мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ	1	Малын гаралтай түүхий эдийг түшиглэж, ноос ноолуур, арьс, шир боловсруулах, элдэх, хүнсний ногоо боловсруулах цех байгуулах.	2020 - 2024	ХААТасаг		Арьс шир элдэх, хүнсний ногоо боловсруулах цехтэй болсон байна.	СХС-аас нэхий элдэх төсөлд 3.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн ноос ноолуур, хүнсний ногоо боловсруулах цех байгуулах аж ахуйн нэгж, иргэний хүсэлт одоогоор ирээгүй байна.	70%
	2	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж хэвшүүлэх	2020 - 2024	ХААТасаг		ЖДҮ-ийг дэмжиж дунджаар 60 иргэн, ААН-ийг зээлээр дэмжсэн байна.	2021 онд Монгол Улсын Засгийн газрын 42,59 дүгээр тогтоолоор баталсан Хөдөө аж ахуй, бизнесийн үйл ажиллагааг дэмжих 3 хувийн зээлийг ХААН, Төрийн банкаар дамжуулан 103 малчинд мал тоо толгойг өсгөх, малын үүлдэр угсааг сайжруулахад 643,200,000 төгрөг, 117 бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх чиглэлээр 3,122,500,000 төгрөгийн зээл олгож, 220 ажлын байр хадгалагдсан. СХС-аас 12 иргэнд 49,0 сая төгрөгийн зээлийг олгож шинээр 7 ажлын байр нэмэгдэж, 5 ажлын байрыг хадгалсан.	100%

	3	Сумын онцлог, өв уламжлалыг харуулсан бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брендэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих ажлын байр бэлтгэх.	2020 - 2024	ЗДТГазар ХААТасаг		15 иргэнийг шинээр ажлын байртай болгоно	Шинээр брэнд бүтээгдэхүүнтэй болох, үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор Сум хөгжүүлэх сангаас "Жаргалхүү ХХК"-ийн "Хатан зөгий" үржүүлэх төсөлд 5,0 сая төгрөг, иргэн Э.Мөнхсайханы нэхий элдэх төсөлд 3,0 сая төгрөг, иргэн С.Даваанямын "Үндэсний урлан" монгол гутлын төсөлд 5,0 сая төгрөг, иргэн Б.Аюушжавын "Гэрийн мод үйлдвэрлэл"-ийн төсөлд 5,0 сая төгрөг, иргэн П.Бямбасүрэнгийн "Евро хашаа үйлдвэрлэл"-ийн төсөлд 4,0 сая төгрөг, иргэн Ч.Цэрэндолгорын "Монгол дээл, монгол хувцас"-ны төсөлд 3,0 сая төгрөг, нийт 5 иргэн, 1 аж ахуйн нэгжид 25,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгоод байна. "Өвөрхангай түншлэл 2021" намрын үзэсгэлэн худалдаанаас "Хангайн бал" хоршооны зөгийн бал орон нутгийн шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан"-гаас "Арвинлхам очир" ХХК нь сав баглаа боодол буюу мод модон сав суулга хийх чиглэлээр 45.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг авч үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.	70%
	4	"Бат-Өлзийд үйлдвэрлэв" худалдааны төв нээж, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний худалдаалах боломжийг бүрдүүлж, цахим орчинд сурталчилан таниулах онлайн худалдааг хөгжүүлэх.	2020 - 2024	ЗДТГазар ХААТасаг		Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах төвтэй болж, онлайнаар сурталчилгааг хийсэн байна.	"Бат-Өлзийд үйлдвэрлэв" худалдааны төвтэй болохоор Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөлд саналаа хүргүүлсэн. Төслийн шийдвэр 2022 оны 1-р сард гарах талаар төслийн ажилтан мэдэгдсэн. Бат-Өлзий зарын нэгдсэн группээр "Бат-Өлзийд үйлдвэрлэв" дэлгүүр ажиллуулбал бараа бүтээгдэхүүнээ худалдах иргэн байгаа эсэх талаар зар тавихад 8 иргэн монгол дээл хувцас, эсгий урлал, талх, нарийн боов, гутал, хөөрөгний даалин, эмийн ургамал, зөгийн бал, шар тостой монгол архи зэргийг дэлгүүрт тавьж борлуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.	70%
	5	Байгалийн нөөцийг зохистой ашиглах, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр 300 га хүртэл	2020 - 2024	ХААТасаг		300 га-д малын тэжээл, жимс	Малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхээр атаршсан газрыг эргэлтэнд оруулж 200 га газрын хэмжилт хийн олгож, үүнээс 50 га газарт хөрс боловсруулалтын ажил хийж, 31 га газарт ногоон тэжээл тариалсан. Үүнээс гадна өвөлжөө,	100%

		талбайг эзэмшүүлж эргэлтэнд оруулна.				жимсгэнэ тариулсан байна	хаваржааны хөлд 31 малчин ногоон тэжээл тарьсан. Жимс жимсгэнэ тариалах зориулалтаар 4 дүгээр багийн төвийн урд хэсэгт 2 га газар олгосон. Баруун сөдтийн алтны уурхайн ухмал талбайд 2 га газарт нөхөн сэргээлт хийн ногоон тэжээл тариалсан нь Өвөрхангай аймгийн зорилтот жилийн хүрээнд зарласан уралдаанд Д. Бямбасүрэн ахлагчтай малчдын 10-тын бүлэг "Шилдэг аравт"-аар шалгарсан.	
	6	Сумын аялал жуулчлалын маршрутын дагуух зам, гүүр, дэд бүтцийн нөхцөлийг сайжруулах.	2020 - 2024	ЗДТГазар		Аялал жуулчлалын зам сайжирна	Бат-Өлзий сумын Орхон голын 220 м урттай, төмөр бетонон гүүр, Цагаан гол, Могойтын гол, Үүртийн тохойн төмөр бетонон гүүрүүд, Могойтын голоос Орхон гүүр хүртэлх 6.7 км сайжруулсан зам ашиглалтанд бүрэн орсон.	100%
	7	Гурван модны хөвөөний замыг засах.	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа		Аялал жуулчлалын зам сайжирна	2022 онд төлөвлөгдсөн.	
1.2. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ								
	8	Сумын төв доторх хатуу хучилттай замын дутууг гүйцээх	2020 - 2024	ЗДТГазар	Улсын төсөв	2 км	Сумын төвийн 2 км авто замын шинэчлэлийг "Өвөрхангай-Азза" ХХК гүйцэтгэн, ашиглалтанд оруулсан.	100%
	9	Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн авто замыг шинээр барих зураг төсвийг хийлгэж барьж эхлэх.	2020 - 2024	ЗДТГазар	Улсын төсөв		Хужирт-Бат-Өлзий сумын асфальтан зам тавигдах зураг төсөв хийгдсэн. 2022 оноос замын ажил эхэлнэ.	70%
	10	Наймаа булан, Өвт, Бэл хорооллын үерийн далан барих.	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа	ОНХСан	Үерийн далан баригдсан байна.	Үерийн далан барих зураг төсөв хийгдсэн. 2022 онд хийгдэнэ.	70%
	11	Цаг уур, Наймаа булангийн 6 дугаар гудамжаас хойш, Өвтийн 17 дугаар гудамжнаас хойш, Бэлийн 11 дүгээр гудамжнаас хойш өргөн	2020 - 2024	ЗДТГазар			Хэрэгжих хугацаа болоогүй.	

		чөлөөнд гэрэлтүүлэг тавих						
12		Бүрэгтий багийн төвийг өндөр хүчдэлд холбох, худаг гаргаж суурьшилын бүс болгох.	2020 - 2024	ЗДТГазар			2022 оны ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлаар 1 дүгээрт эрэмбэлэгдсэн.	50%
13		Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг хариуцах чиг үүрэг бүхий нэгж байгуулж, бүтэц орон тоо бий болгох	2020 - 2024	ЗДТГазар	ОНТөсөв 19,0		Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг ТӨҮК-тай гэрээгээр гүйцэтгүүлж байгаа, одоогоор 4 орон тоотойгоор ажиллаж байна.	100%
14		Улаан голыг төмөр бетон хийцтэй хөлтэй, модон тавцантай гүүр барих	2020 - 2024	ЗДТГазар	250,0		Улаан голын бетонон гүүрийг ОНХСан, орон нутгийн хөрөнгөөр "Мотор сервис" ХХК барьж ашиглалтанд оруулсан.	100%
15		Улиастай болон Улаан амны багийн төвийн барилга барих.	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа	ОНХСан 60,0		Улаан ам багийн төв шинээр баригдаж, ашиглалтанд орсон смсс.	70%
16		Сумын төвд цамхагт гэрэлтүүлэг 2-ыг барих.	2020 - 2024	ЗДТГазар Бизнесийн холбоо			2023-2024 онд хийгдэхээр төлөвлөгдсөн.	
17		Ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор үйлчилгээний цогцолбор төв барих. /үсчин, зурагчин, гоо сайхан, оёдол, фитнес, халуун ус, саун, цайны газар/	2020 - 2024	ЗДТГазар хувийн хэвшил			"Бизнес хөгжлийн төв"-д үсчин, гоо сайхан, оёдол, гутал засвар, вакум цонхны үйлдвэрлэлийн чиглэлээр 12 иргэн давхардсан тоогоор 7350 орчим иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан. 12 иргэнтэй түрээсийн гэрээг шинэчлэн хийж арга зүйн зөвлөгөө өгч мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.	90%
18		Улаан-Ам багийн Улааны хэжүү, Амгалангийн хошууны замыг засварлах	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа иргэд		2 зам засварлагдсан байна.	Улаан ам багийн Хэжүүгийн замыг "Мотор сервис" ХХК өргөсгөн засварласан.	70%
19		Зөрүүлэг багт нийтийн халуун ус барих.	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа			2022 оны ОНХСангийн санхүүжилтээр хийхээр эрэмбэлэгдсэн.	50%
20		Улаан ам, Бүрэгтий багийн төвд хүний эмчийн барилга барих, Улаан амны эмнэлгийг өрхийн эмнэлгийн статустай болгох. /Их эмчийн салбартай	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа			Хэрэгжих хугацаа болоогүй. /2023-2024/	

		болгоно/						
	21	Ахмадын хөгжлийн төвийг шинээр барьж, ашиглалтанд оруулна.	2020 - 2024	ЗДТГазар Ахмадын хороо	40,0		Цагдаагийн хуучин кабон байрыг Ахмадын хорооны байр болгон улсын төсвийн 40,0 сая төгрөгийн хөрөнгөөр бүрэн засварлаж, хүлээлгэн өгсөн.	100%
	22	Сумын төвийг танилцуулах, сурталчилах өндөрлөгтэй болгох.	2020 - 2024	ЗДТГазар Бизнесийн холбоо			Сумын төвийг танилцуулах, сурталчилах өндөрлөг барихаар нийт 105 бизнесмен хандив өгч 11,0 сая төгрөг цуглараад байна. Сум байгуулагдсаны 100 жилийн ойн ажлын хүрээнд өндөрлөгийн зураг төсвийг хийлгэсэн.	70%
	23	Хүүхдийн “Хөдөлмөр амралтын зуслан” шинээр барьж ашиглалтанд оруулна.	2020 - 2024	ЗДТГазар ХААТасаг			Хугацаа болоогүй.	
	24	Улс, аймгийн хамгаалалтад байдаг болон Дэлхийн өвд бүртгэлтэй түүх соёлын дурсгалтуудыг дэс дараалалтайгаар хашаажуулж, хамгаалалтыг сайжруулна.	2020 - 2024	ЗДТГазар Соёлын төв			Улсын хамгаалалтанд байдаг Төвхөн хийдийг хамгаалахаар Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газраас 1, орон нутгаас 1, нийт 2 орон тоог батлуулан шийдвэрлээд байна. Бөхөн шарын Адгийн буган чулуу, Өндөр хясааны буган чулуу, Урд-Агуйтын булш хэрэгсүүр, Хөшөө хонхорын хөшөөний хашааг сэргээн засварласан.	70%
	25	Зүүн сөдөтийн Дунд халзангийн даваа, орон нутгийн чанартай шаардлагатай ны замуудыг засварлах.	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа			2022-2023 онуудад төлөвлөсөн.	
	26	Хогийн цэг рүү цахилгааны шугам татах	2020 - 2024	ЗДТГазар ТӨҮК	10,0	Цахилгааны эх үүсвэртэй болох	Сумын төвөөс Хогийн цэг хүртэл 10 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг орон нутгийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн.	100%
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ								
Зорилт: Байгаль цаг уурын нөхцөлд зохицсон	27	Сумын төвийн тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн	2020 - 2024	ХААТасаг			Өвс тэжээлийн агуулахыг 2,4 дүгээр багт барьж ашиглалтанд оруулсан. Газар тариалангийн шаардлагатай тоног төхөөрөмжийн захиалга өгсөн санал ирүүлсэн аж	70%

<p>бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулах, усан хангамжийг нэмэгдүүлэх төмс, хүнсний ногоогоор дотоодоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>		<p>хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотойгоор аж ахуйн нэгж байгуулан газар тариалан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллуулна.</p>					<p>ахуйн нэгж, иргэн байхгүй байна.</p>	
	28	<p>Сумын өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд “Атаршсан талбай”-г эргэлтэнд оруулж 200 га-аас доошгүй газарт ногоон тэжээл тариална.</p>	2020 - 2024	ЗДТГазар ХААТасаг		Атаршсан газарт ногоон тэжээл тариална.	<p>Малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхээр атаршсан газрыг эргэлтэнд оруулж 200 га газрыг хэмжилт хийн олгож үүнээс 50 га газарт хөрс боловсруулалтын ажил хийж, 31 га газарт ногоон тэжээл тариалсан</p>	90%
	29	<p>Стандартын шаардлага хангасан “Мал нядалгааны цэг” байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин газрын асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана.</p>	2020 - 2024	ЗДТГазар ААНэгж, иргэн			<p>“Мал нядалгааны цэг” байгуулах хүсэлтийг “Малчдын хамтын хүч” хоршооноос ирүүлсэн. Газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулан шийдвэрлүүлнэ.</p>	70%
	30	<p>Хүнсний ногооны зоорь байгуулах иргэн, аж ахуйн нэгжийн саналыг дэмжин газрын асуудлыг шийдэж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад анхаарч төсөл, хөтөлбөрөөр дэмжин хамтран ажиллана.</p>	2020 - 2024	ЗДТГазар ХААТасаг			<p>Бэлчээр ашиглалын холбоонд хүнсний ногооны зоорь барих саналаа хүргүүлсэн. Зоорь нь 80,0 сая төгрөгийн төсөв өртөгтэй, үүний 50 хувийн санхүүжилтийг нь орон нутгаас гаргахаар шийдсэн.</p>	50%

	31	Хөдөө аж ахуйн агропарк барьж ашиглалтанд оруулна.	2020 - 2024	ХААТасаг			Хугацаа болоогүй.	
	32	Сумын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Улиастай” багийн Улиастайн дэнжийн нам оруулга, Горхин дэнж, Улаан ам багийн Мухдаг, Бүрэгтий багийн төв, Дэндгэр, Билүүтийн хөндлөн, Баруун сөдөт, Зөрүүлэг багийн Урд Агуйт, Нарийн, Хойд агуйт, 5 дугаарт баг, Могойтын ам зэрэг газарт худгуудыг шинээр гаргах.	2020 - 2024	ЗДТГазар ХААТасаг		Баригдсан худгуудын тоогоор	Энэ онд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 4 худаг шинээр гаргасан. Үүнд:1 дүгээр багийн Мухдаг, 2 дугаар багийн Баруунсөдтий, Зүүнсөдтий, 4 дүгээр багийн Урд-Агуйт гэх газруудад гаргаж аймаг, сумын ажлын хэсгүүд хүлээн авсан.	100%
	33	Малын гоц болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж Улиастай багийн Боймт, Шивэртий, Бөөрөг, Улаан ам багийн Бургас, Мухдагт мал тарилгын хашаа барина.	2020 - 2024	ЗДТГазар МЭТасаг		Тарилгын хашааны тоогоор	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт тарилга гүйцэтгэх, эрүүл бүс, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж Сум дундын ойн анги"-тай тарилгын хашааны модны зөвшөөрлийг авч 1,6 дугаар багийн Боймт, Шивэртий, Бөөрөг, Бургас, Мухдагт нийт малын тарилгын 5 хашаа баригдсан.	100%
	34	Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг тогтмолжуулж Бүрэгтий багийн Баруун сөдөтөд мал угаалгын ванн барина.	2020 - 2024			Мал угаалгын ванн тоогоор	Мал эмнэлгийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, гадна шимэгчийг устгаж халдваргүйжүүлэх зорилгоор Бүрэгтий багийн Сөдтийд мал угаалгийн ванн баригдсан.	100%
	35	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр	2020 - 2024	ЗДТГазар МЭТасаг		Мал эмнэлгийн үйл ажиллагааг цахимжуулна.	2021 онд 378 гэрчилгээ бичигдэж, мал эмнэлгийн гэрчилгээний бичилт, баталгаажуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, гэрчилгээг шуурхай олгож, системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Амьд мал бүгд 3778 толгой адуу-980, үхэр-1238, ямаа-630, хонь-939/, мах махан бүтээгдэхүүн 60755 кг /адууны мах 980 кг, үхрийн	100%

		малын эмч, нэгжүүдийн малын эмч нарыг хангах үйлчилгээг цахимжуулна.					мах-51405 кг, хонины мах-7335 кг, ямааны мах-1035 кг/, сүү сүүн бүтээгдэхүүн 146390 кг /аарц 142600 кг, өрөм 20 кг, ааруул 170 кг/, ноос 38004 кг , ноолуур 6500 кг тус тус тээвэрлэгдсэн байна . "Мал аж ахуй эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх" төсөлтэй хамтран ажиллаж, мал эмнэлгийн үйлчилгээний 3 нэгжийн эмч, тасгийн тархвар зүйч нарыг таблетаар хангасан.	
1.3. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ЧИГЛЭЛЭЭР:								
Зорилт 1: Гол ус, булаг шандны эхийг хамгаалах, аялал жуулчлалыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.	36	Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагыг дэмжиж, сумын төвийн засмал зам дагуу ногоон байгууламжтай болгох, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.	2020 - 2024	ЗДТГазар Ойн анги	26,1	2500	Сумын төвд ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд засмал зам дагуух 0,25 га талбайд ногоон байгууламж шинээр байгуулж, нийт 9500 мод тарьсан.	100%
	37	Усны нөөц нэмэгдүүлэх, булаг, шандны эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх төслийг дэмжинэ	2020 - 2024	ЗДТГазар Байгаль орчин	15,5	2	Сумын хэмжээнд усны нөөц нэмэгдүүлэх, булаг, шандны эх хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд 2 булгийн эхийг хашсан. / Хүйтэн булагт 200 м урттай, Дунд булагт 100 м урттай төмөр хайсан хашаа/	100%
	38	Сумын хогны менежментийг сайжруулж, хог хаягдал дахин боловсруулах цех байгуулах, хог шатаах зуухтай болох	2020 - 2024	ЗДТГазар ТӨҮК	30,0	2	Сумын хогны менежментийг сайжруулах хүрээнд төрийн өмчит үйлдвэрийн газрын харъяа нэгдсэн хогийн цэгт эрчим хүчний шугам тавьсан. Хог хаягдал дахин боловсруулах цех байгуулахад 2 ширхэг преслегч машинтай болгосон. Хог ангилан ялгах хашаа барьсан. Үйлчилгээний байгууллага, дэлгүүрүүдийн гадны хог ангилан ялгах хогийн савыг байршуулсан.	90%
	39	Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хамгаалалтын менежментийг	2020 - 2024	ЗДТГазар	15,0	2	Ургамлын төрөл зүйлийн судалгааны ажил аймагтаа гэрээ байгуулан манай суманд 8 сард хийгдсэн. Иргэд, ТББ-уудын хандиваар нийт 800 боодол өвс, хужир давс 100 кг, 0,5 тн хужир шүүг нэн ховор, ховор амьтад хамгаалах зорилгоор тавьж, биотехникийн арга хэмжээг 5 удаа зохион	100%

		сайжруулна.					байгуулсан.	
	40	Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулна	2020 - 2024	ЗДТГазар ОХБЦГазар	45,0	1	Угтах 2 отог ажиллуулж, аялагчдад 80 мориор үйлчилгээ хийж хүргэсэн.	100%
	41	Үүртийн тохой-Төвхөн хийд, Улаанцутгалан-Бат-Өлзий гэсэн аялал жуулчлалын маршрутаар хөгжүүлнэ.	2020 - 2024	ЗДТГазар	210,0	2	Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ИТМ жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлал эрхлэгч 4 жуулчны бааз зохион байгуулалттайгаар оролцож, аялал жуулчлалын тур операторуудтай уулзалт хийж амжилттай оролцсон. Орон нутагт 14000 аялагчид аяласан байна.	100%
	42	Найман нуур, Улаан голын Хүрхрээгийн мөсөнд авиралт, Өндөр хясааны сарлагийн фестиваль гэсэн тусгай сонирхлын аялалын маршрутыг хөгжүүлнэ.	2020 - 2024	ЗДТГазар		2	Найман нуурыг Бөөргийн жуулчны бааз /3 өдөр, 2 шөнийн хөтөлбөр“ морин аялалд нийт 1000 гаруй аялагч хамрагдсан. Уламжлал болсон Хүрхрээгийн мөсөнд авиралтын тэмцээнийг “KHARAKHORUM ICE FESTIVAL-2021” өвлийн эвент хөтөлбөрт спортын тамирчид, аялагч, иргэд оролцон тусгай сонирхлын аялалын маршруттай аялалууд хөгжиж байна. Энэ арга хэмжээг аймаг, орон нутгийн зүгээс 2 сая төгрөгний дэмжлэг үзүүлж ажиллаа.	100%
1.4. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ								
Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ	43	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2020 - 2024	ЗДТГазар НБМ		Үйл ажиллагааны хэрэгжлээр	Ковид цар тахлын улмаас танхимын сургалт зохион байгуулах боломжгүй тул хамтарсан багийн гишүүд 5 болон 7 дугаар саруудад 37 гэр бүлээр орж гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцааны ёс зүйн, хүүхдийн хүмүүжил, гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн уламжлалт зан заншил, эрүүл мэндийн боловсролын талаар мэдээлэл өгч, брошур, гарын авлагыг тараасан. Гэр бүлийн боловсролтой холбогдон гарсан хууль, дүрэм, журмыг иргэдэд цахимаар хүргэн ажиллаж байна. Танхимын сургалтын үйл ажиллагаа нээвэл гэр бүлийн судлаач багшийг урьж гэр бүлүүдийг үе шаттайгаар сургалт хамруулахаар төлөвлөж байна.	90%
	44	Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг	2020 - 2024	ЗДТГазар НБМ			2021 оны 7 дугаар сард хуучин цагдаагийн байранд их засвар хийж 2 өрөөг гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх өрөө болгож байгаа юм. Хамгаалах байр маань ор, зөөлөн эдлэл, ус буцалгагч, халуун тогоо, аяга халбага, усны сав, сандалтай болсон. Цаашдаа ширээ сандал,	100%

		нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.					буйдан, ор, номын тавиур, халуун сав, телевизор, тохиоллын систем, гоожуур зэргийг авах шаардлагатай бөгөөд эдгээр зүйлсийг ЗДТГ-ын даргад танилцуулж шийдвэрлүүлэхээр болсон. Хамгаалах байрны хувьд цагдаагийн байртай ойрхон байгаа нь давуу талтай. Хамгаалах байртай болсноор хүчирхийлэлд өртөгч нарыг хамгаалах байрандаа авч хамгааллын үйлчилгээг үзүүлэх, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээ мэдээлэл өгөх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилах, ярилцах боломж бүрдэх юм. Энэ онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ээж хоёр охины хамт хамгаалах байранд авч 3 сар амьдарсан. Энэ хугацаанд ээжтэй ярилцаж, сэтгэл санааг нь дэмжих зорилгоор сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг тогтмол өгч ажилласан. 2021 оны 07 дугаар сарын 29 нд өөрсдийн хүсэлтээр гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Мөн 2021 оны 12 дугаар сарын 07-ний өдөр хүчирхийлэлд өртсөн ээжийг хамгаалах байранд авч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Хүчирхийлэл үйлдэгч нар болон хүчирхийлэлд өртөгч нийт 31 иргэнд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг өгч ажилласан.	
	45	Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна.	2020 - 2024	ЗДТГазар Хамтарсан баг		Сургагч багш нараар дамжуулан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтанд эцэг эхчүүдийг үе шаттай хамруулан, хандлагыг өөрчилсөн байна	Ковид-19 цар тахлаас шалтгаалан танхимын сургалт зохион байгуулах боломжгүй учир “Хүүхдийн хөдөлмөрт үгүй гэж хэлье”, “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” зөвлөгөө, “Хариуцлагатай аав, ээж” энгийн дүрэм, “Бага насны хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлэх”, “Сүүдэр бүү тусга” аяны зөвлөмж, шторк, “Хүүхдийн ертөнцийг хайрлая хамгаалъя”, “Хүүхэддээ хайраа харуулах бодит арга замууд”, “Хүүхэд бол маш том ертөнц”, “Хүүхдийн хөгжил”, “Амь нэгтэй хөршүүд”, “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай”, “11-15 насны хүүхдэд амьдралыг таниульа, өөрийнх нь хүчинд итгүүлье”, хүүхдийг эерэгээр хүмүүжүүлэх 8 арга, “Хүүхдээ дэлгэцийн хамаарлаас сэргийлье” зөвлөмжийг эцэг эхчүүд, иргэдэд цахимаар тогтмол хүргэж ажилласан. Хүүхэд нэг эрдэнэ, хүмүүжил мянган эрдэнэ, Хүүхдийн хөгжлийн онцлог, Хүүхдээ хайрлая, хүүхдийн аюулгүй дүрэм, хүүхэд хүмүүжлийн эерэг арга гарын авлагыг нийт 312 эцэг, эхэд тарааж ажилласан.	100%
	46	Төрийн болон төрийн бус	2020	ЗДТГазар		Хөдөөгийн	Нэг өрх-Нэг шинжилгээ 7 хоногийн аян зарлаж	100%

		байгууллагатай хамтран хөдөөгийн залуучуудыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.	- 2024	НБМ		15-34 насны залуучуудад хүрч ажилласан байна.	хөдөөгийн өрхүүдээр явж шинжилгээ авахдаа хөдөөгийн залуучуудад ковидоос хэрхэн урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалалтын дэглэмийг барих, хэрхэн урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Ковидтой холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг ард иргэдэд сумын группээр дамжуулан тогтмол хүргэж байна. Цэргийн насны 315 залуучууд үзлэгт хамрагдсан. Үзлэгт хамрагдсан залуучууд бүрт БЗДХ-аас сэргийлэх зөвлөгөө өгч, зөвлөмж тараасан. Залуучуудын дунд шүдний өвчлөл, Бөөр шээсний замын эмгэг хамгийн их хувийг эзэлж байна. Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Эрүүл мэндийн нийгмийн ажил, багийн эмч нартай хамтран "Тамхины хор хөнөөл", "Архины хор уршиг" гарын авлагыг бэлтгэн сумын төвийн айл өрхүүдээр орж 15-34 насны 49 залууд тарааж мэдээ мэдээлэл өгч ажилласан. "ӨВ ХАМГААЛАГЧ" аяны хүрээнд ТСҮХД, биет болон биет бус өв, баримтат өвийн талаар 15-34 насны 43 залууст мэдээлэл өгч, гарын авлага тараалаа. Сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/106 тоот захирамжаар суманд залуучуудын хөгжлийн салбар зөвлөл 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан хуралдаж хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө гаргаж төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа хийж хэрэгжүүлэн ажиллаж байна. Зөвлөлийн гишүүд Хүйтэн булгийн эхийг хаших ажлыг өөрсдийн санаачилгаар цалин, урамшуулалгүй гүйцэтгэсэн.	
ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОРИЛТУУД								
Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг	47	Сумын иргэдийг урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах хамрагдалтын хувийг 30%-д хүргэнэ	2020 - 2024	ЭМТөв			-Нийт амбулаторын үзлэг 12875 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт давхацсан тоогоор 7957 хүн хамрагдсан. -2021 оны 1 улиралд 2-5 насны 500 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, халдварт саа өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины нөхөн дархлаажуулалтанд хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 500 хүүхдээс 356 хүүхэд 71,2% шүдний өвчлөлтэй байсан. -Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын урьдчилан сэргийлэх үзлэгт 18 дээш насны 4496 хүн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаа	100%

нэвтрүүлэн эмчилгээ үйлчилгээний хүртээмжийг сайжруулна						<p>хамрагдсан.</p> <p>-12-17 насны 813 хүүхэд ковид 19 халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдаж 2 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.</p> <p>-7, 15 настай 258 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 255 хүүхдэд сахуу татрангийн вакцинд хамруулсан.Ханиадны улмаас 2 хүүхдэд, идээт үрэвслийн улмаас 1 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн.</p> <p>-9-12 ангийн 230 охидыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.</p> <p>-Умайн гаднах жирэмслэлт 1 илрүүлж сумандаа яаралтай тусламжийн арга хэмжээ авч БОЭТ-ийн хагалгааны багийг дуудаж амь насыг аварсан.</p> <p>-Бөөрний архаг дутагдалтай 2 иргэнийг илрүүлж дээд гшатлалын эмнэлэгт илгээж хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгож хөдөлмөр зохицуулалт хийсэн.</p> <p>-Зүрх судасны эмгэгтэй 6 хүнийг шинээр илрүүлж эмнэлгийн хяналтанд авч эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>-Урьдчилан сэргийлэх үзлэгээр хавдрын урьдалтай 4 иргэнийг илрүүлж онош тодруулахаар дээд шатлалын эмнэлэгт илгээсэн.</p> <p>-Артерийн даралт ихсэлт, чихрийн шижин, элэгний хавдрын эрт илрүүлэгт нийт 608 иргэн хамруулсан. Үүнээс артерийн даралт ихсэлттэй 13 иргэнийг шинээр илрүүлж хяналтанд авч эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>-Хөхний үзлэгт 1310 эмэгтэй хамрагдсан ба өөрчлөлтэй 4 хүн илэрч дээд шатлалын эмнэлэгт илгээсэн.</p> <p>-Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн нийт 109 хүн хамрагдсанаас уман хүзүүний хорт хавдартай 1 хүн илэрч хавдар судлалын үндэсний төврүү эмчлүүлэхээр илгээсэн</p>	
	48	Эмч, мэргэжилтнүүдийг үе шаттайгаар сургаж жил бүр 3 хүртэл хүнийг	2020 - 2024	ЭМТөв		2 их эмчийг хүүхэд, эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчээр суралцуулж, эмэгтэйчүүдийн	100%

		сургалтанд хамруулна.					их эмч төгсөж ирээд ажиллаж байна. 2021 онд 2 их эмчийг дотрын нарийн мэргэжлээр суралцуулж байна. Энэ онд 15 удаагийн цахим сургалтад давхацсан тоогоор 69 эмч, мэргэжилтэн, 7 удаагийн танхимийн сургалтанд 12 эмч, мэргэжилтэн /үүнээс УБ-т 1, Арвайхээрт 6/ хамрагдсан.	
	49	Орчин үеийн дэвшилтэт рентген аппараттай болгоно.	2020 - 2024	ЭМТөв			ЭМГазраас ЭМТөвүүдийг үе шаттайгаар рентген аппараттай болгох шийдвэртэй байгаа.	50%
	50	Биохими болон шээсний анализатортой болгоно.	2020 - 2024	ЭМТөв			2021 оны 09 сард Биохими болон шээсний анализаторын аппараттай болсон. 2021 оны 11 сард ЭМТ-ийн лаборант биохимийн аппаратыг таниулан ажиллуулах сургалтанд хамрагдсан. Одоогоор шинжилгээний уусмал нийлүүлэгдээгүй байна.	100%
	51	Төвийн дуудлагын авто машинтай болгоно	2020 - 2024	ЗДТГазар ЭМТөв			Хугацаа болоогүй..	
	52	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор алсын дуудлагын авто машины парк шинэчлэлт хийнэ.	2020 - 2024	ЭМТөв			Түргэн тусламжийн 2 автомашинд сумын Засаг даргын нөөцөөс 6,336,000 төгрөгний урсгал засвар, ЭМТ-өөс түргэн тусламжийн автомашинд 1,500,000 төгрөгний засвар үйлчилгээг тус тус хийсэн.	100%
	53	Багийн эмч нарыг компьютер хэрэгслээр хангана.	2020 - 2024	ЭМТөв			2 дугаар эмчид орон нутгийн төсвийн 2,9 сая төгрөгийн өртөг бүхий мотоциклээр унаажуулсан. ЭМГазраас багийн эмч нарыг 3 суурин компьютер хэрэгслээр хангасан.	100%
	54	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг шинээр барих.	2020 - 2024	ЗДТГазар ЭМТөв		1 эмнэлэг шинээр баригдана	15 ортой эмнэлгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв хийгдсэн. Мөн газрын хөрсний шилжилгээг хийсэн.	70%
	55	Эмчийн байрыг засварлах ба шинээр эмчийн байр	2020 - 2024	ЗДТГазар ЭМТөв			Эмчийн байрыг 2020 онд засварласан.	

		барина.						
	56	Шүдний эмчтэй болох	2020 - 2024	ЗДТГазар ЭМТөв			Шүдний эмч орон тоогоор ажиллаж байгаа. Шүдний эмчийг тоног төхөөрөмжтэй болгох зорилгоор ЭМГазар албан хүсэлтийг удаа дараа хүргүүлэн шүдний эмчийг Ворын аппараттай болгосон	100%
2.2. БИЕЙН ТАМИР								
Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшил тогтоох, гэр бүлийг дэмжих, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	57	Иргэдийн дунд “Миний нутаг сайхан” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.	2020 - 2024	ЕБС БТАЗүйч			Цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй.	
	58	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжин биеийн тамирын арга зүйчтэй болгоно.	2020 - 2024				Биеийн тамирын арга зүйчийн цалингийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.	90%
	59	Хүүхэд залуучуудын спорт цогцолбор барина	2020 - 2024	ЗДТГазар ЕБС			Хугацаа болоогүй.	
	60	Өсвөр үеийг спортоор хичээллүүлэх ажлыг дэмжин жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, даам, цана, гар бөмбөг, сагсан бөмбөг, теннисний төрлүүдээр шигшээ баг бүрдүүлнэ.	2020 - 2024	ЕБС			Өсвөр үеийн жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, даам, цана, гар бөмбөг, сагсан бөмбөгний төрлөөр багууд хичээллэж, аймгийн аварга шалгаруулан сагсан бөмбөгийн тэмцээнд 3 дугаар байранд шалгарч, “Хүрэл медаль”, үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд сурагч Саранцогт 7 дугаар байранд, үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах уралдаанд 3 дугаар байранд, аймгийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 3 дугаар байр, 3 сурагч “Мөнгөн медаль” хүртсэн амжилтуудыг тус тус гаргасан.	100%

	61	Олон улсын стандартад нийцсэн цанын бааз барина	2020 - 2024	ЗДТГ				Цанын бааз байгуулах газрын асуудлыг шийдэж, орон нутгаас хамааралтай баримт бичгийг холбогдох газарт хүргүүлсэн.	50%
	62	Жил бүр спортын нэрэмжит тэмцээнүүдийг зохион байгуулна	2020 - 2024	ЗДТГ ЕБС				Цар тахлын улмаас энэ үйл ажиллагаа хойшлогдоод байна.	
	63	Сумын хүний хөгжлийн индексийн үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргана.	2020 - 2024	Статистик хариуцсан мэргэжил тэн					
	64	Хөл бөмбөгийн талбайтай болох	2020 - 2024	ЗДТГазар Багийн захиргаа				2022 оны ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажилд иргэдээс эрэмбэлэгдэж орж ирсэн боловч зураг төсөв, хөрөнгийн асуудлаас шалтгаалан дараагийн жилүүдэд хийгдэхээр төлөвлөсөн..	50%
2.3. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БОДЛОГО ЗОРИЛТУУД.									
Зорилт 1. Багш сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулан, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	65	Суманд 440 хүүхдийн сургуулийн барилга шинээр барина.	2020 - 2024	ЗДТГазар ЕБС	5,3 тэр бум	1		440 хүүхдийн сургууль шинээр барих ажил эхэлсэн	70%
	66	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барина	2020 - 2024	ЗДТГазар ЕБС	1,2 тэр бум	1		150 хүүхдийн цэцэрлэг браих ажил эхэлсэн. Ажлын явц 30%-тай.	70%
	67	Спорт заал шинээр барина.	2020 - 2024	ЗДТГазар ЕБС				440 хүүхдийн хичээлийн байр спорт заалтай баригдана	70%
	68	Сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ.	2020 - 2024	ЗДТГазар ЕБС				Энэ жилийн төлөвлөлтөнд ороогүй	
	69	Багш хөгжлийн төвийг ширээ, сандалтай болгох.	2020 - 2024	ЕБС	1,885,000			Багш нарын ажиллах орчныг сайжруулах, тав тухтай ажиллах нөхцөл боломжоор хангах үүднээс багш хөгжлийн танхимыг засварлан сайжруулан хариуцах эзэнтэй болгон үйл ажиллагаагаа	100%

							тогтмолжуулан ажиллаж байна. Залуу багш нарын хөгжлийг хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг ЗАН-ийн төлөвлөгөөнд тусган ажилласан. Мөн 2021-2022 хичээлийн жилийн эхэнд багш нарын өөрсдийн санхүүжилтээр ширээ, сандал, печь, хөшиг зэргээр нэмж тохижуулсан.	
70	Хими, мэдээлэл зүйн, биологийн иж бүрэн кабинеттай болгоно.	2020 - 2024	ЕБС	12,194, 380	2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар химийн кабинетыг лабораторийн 70 нэр төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан. Биологийн кабинетад БСШУЯамны санхүүжилтээр хичээл хэрэглэхүүнээр хангагдсан.	90%	
71	ЕБСургууль, 1 дүгээр Цэцэрлэгийн камержуулалтыг орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камертай болгоно	2020 - 2024	ЕБС	9,500,0 00		Сургуулийн 2 хичээлийн байр, 2 дотуур байрны гадна дотно талдаа орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камерыг суурилуулсан. 2021 оны 08 дугаар сард БСУГ-аас цэцэрлэгийн гадна 3 камер, дотор 13 ширхэг орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын нийт 16 камер ирсэн уг камерийг Өвөрхангай аймгаас мэргэжлийн хүн авчирч суурилуулан камерийн бичлэгийг тогтмол хянаж байна.	100%	
72	ЕБСургуульд сэтгэл зүйчийн орон тоог бий болгоно. Мэргэшсэн сэтгэл зүйчээр хангана.	2020 - 2024	ЕБС			Хэрэгжих хугацаа болоогүй.		
73	ЕБСургууль, СӨББ-уудыг хөгжим, техник хэрэгслээр бүрэн хангана.	2020 - 2024	ЕБС, СӨББ-ууд	3,036,8 00		Дуу хөгжмийн кабинетад чанга яригч пулт /УАМАНА/, мөн укулули хөгжим 5 ширхэг техник хэрэгслээр хангасан. СӨББ-ын хөгжим техник хэрэгсэлтэй болох хүсэлтийг УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн.	90%	
74	СӨББ-уудыг 2 ээлжийн зөөлөн эдлэлээр хангана	2020 - 2024	СӨББ-ууд			1 дүгээр Цэцэрлэгт 50 ш, 2 дугаар Цэцэрлэгт 20 ш зөөлөн эдлэлийг Тайваны хүүхдийг ивээх сангаас нийлүүлсэн.	90%	
75	1 дүгээр Цэцэрлэгийн хуучин байрны	2020 -	СӨББ			2020 онд Цэцэрлэгийн хуучин 90 хүүхдийн байрны сантехникийг засварыг хийсэн. 2021 онд улсын	100%	

		сантехникийг шинэчлэх.	2024				төсвийн 8,0 сая төгрөгийн хөрөнгөөр дээврийн засварыг хийсэн.	
	76	1 дүгээр Цэцэрлэгийн цэвэр бохир усны сантехникийн асуудлыг шийдвэрлэнэ.	2020 - 2024	СӨББ			2020 оны 08 сард цэвэр бохир усны сантехникийн засварыг хийсэн.	100%
	77	СӨББ-уудыг хүүхдийн стандартад нийцсэн тоглоом наадгайгаар хангана.	2020 - 2024	СӨББ			Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сангаас 2021 онд Японы хандиваар хүүхдийг тоглонгоо хөгжихөд ихээхэн хувь нэмэр болох тоглоом сургалтын хэрэглэгдэхүүнийг Аймгийн засаг дарга А.Ишдорж гардуулж өгсөн. Үүнд: Цагаан хэрэглэл 30 ш, хөнжил гудас 30 ш, хүүхдийн машин 6, мөлхөлтийн саад 6, соронзтой тоглоом 5, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом 2, эвлүүлдэг тоглоом 5, цифр нүдлэх тоглоом 5ш, авиралтийн шат 2, хайс 2ш. Гадна тоглоомын талбайд хүүхдийн эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжсэн орчинг бүрдүүлэн, байгууллагын хөрөнгөөр будаж засвар хийсэн.	100%
	78	Улаан ам багт суурь боловсрол олгох сургууль, 2 бүлэгтэй Цэцэрлэгийн байр барина.	2020 - 2024	ЗДТГазар ЕБС			Хугацаа болоогүй	
	79	“Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд. Элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авсан багш, сурагчдыг урамшуулах, тэтгэлэгт хамруулах сумын дэд хөтөлбөр боловсруулж, ИТХ-аар батлуулан мөрдөн ажиллах.	2020 - 2024	ЕБС		Арга хэмжээний хэрэгжил тээр	“Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд. Элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авсан багш, сурагчдыг урамшуулах, тэтгэлэгт хамруулах сумын дэд хөтөлбөр боловсруулж, ИТХ-аар батлуулж 2022 оноос хэрэгжүүлж эхлэнэ.	100%
	80	Хүүхэд бүрийг сургуульд тэгш хамруулах боловсролын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Японы	2020 - 2024	ЕБС хамтарсан баг			“Энтрепренешипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх ” хөтөлбөрт 8-12 дугаар ангийн 2 бүлэг буюу 43 суралцагч суралцаж байна. Тухайн сургалтын нээлтийн үйл ажиллагааг	100%

		хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь”, “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслүүдийг хамтран хэрэгжүүлнэ.					албан ёсоор зохион байгуулж, ТСЗ болон сум орон нутгийн удирдлагуудыг оролцуулж, сурагч багш нартаа сургалтыг дэмжих гарын авлагаа гардуулсан. Өдрийн ангийн сургалтыг монгол хэл болон англи хэлний кабинетад 7 хоногт 6 цагаар судлах боломжит хичээлийн хуваарийг гарган сургалтаа эхлүүлсэн. Тус сургалтад нийт 48 суралцагч хамрагдахаар байсан боловч хувь суралцагчийн хувийн шалтгаанаас болж 5 сурагч сургалтанд хамрагдаж чадаагүй. Сургалтын чиглүүлэгч багшаар Монгол хэлний багш Б.Даваажав, нийгмийн ухааны багш Ж.Доржханд нар маш идэвхи чармайлттай ажиллаж байна. Одоогоор сургалт 4 долоо хоног үргэлжлэн суралцагчдад хичээл сургалтын үйл явц сонирхолтой байж, өөрийн ур чадвараа хэрхэн хөгжүүлэх боломжийг судалж, зорилгоо зөв тодорхойлон ирээдүйд өөртөө итгэлтэй зөв хүн болж хөгжихөд тухайн сургалтын үр дүн харагдаж байна. Насан туршийн ангид нийт 24 суралцагч хамрагдахаас 20 суралцагч хамрагдах хүсэлтээ өгч 8 залуучууд суралцаж байна. Өнөөгийн хүнд цаг үед отор, нүүдэлтэй холбоотойгоор сурагчдын ирц хангалтгүй, буурах хандлагатай байна. Сургалтын талаарх цаг үеийн мэдээлэл, хүндрэл бэрхшээлийн тухай аймгийн ТЗ-өөс зохион байгуулж буй онлайн сургалт мэдээлэлд тухай бүрд нь бүрэн хамрагдаж мэдээ мэдээллийг цаг тухайд нь авч байна.	
	81	Уламжлалт монгол ахуй, өв соёлоо сэргээн хөгжүүлэх зорилгоор угийн бичиг хөтлөх, монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2020 - 2024	Соёлын төв ЕБС ЗДТГ азар			<p>“Угийн бичгээ бичиж хэвшье” аянг зохион байгуулж, нийт 15 бүлгийн 385 сурагч, 125 багш, ажилтан, албан хаагчид хамрагдсан.</p> <p>Дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>6-9 р ангийн сурагчдын дунд угийн бичгээ хэрхэн хөтлөх вэ? - сургалтыг хүргэж, жишиг даалгавар өгч, аав ээжтэйгээ хамтарч ажиллан, угийн бичгээ хөтлөх ажлыг эхлүүлсэн.</p> <p>Дараах 8 сэдвүүдийн хүрээнд нийт 377 сурагчдаар эссэ бичүүлсэн.</p> <p>➤ Зөв сэтгэлийн ач тус, буруу сэтгэлийн хорыг ухаарах</p>	90%

							<ul style="list-style-type: none"> ➤ Эх оронч үзэлтэй байх нь ямар чухал болох ➤ Өв соёлоо эрхэмлэх, эх оронч сэтгэлгээ ➤ Ёс заншил, монгол ахуйгаа таньж мэдэх ➤ Уламжлалт ёс, өв соёлоо хүндэлж хамгаалдаг байх ➤ Бие, хэл, сэтгэлээр үйлдэх сайн үйлүүд ➤ Гэр бүл, анги хамт олон, бусад хүний болон нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа сайтар ухамсарлах ➤ Эв эетэй байх <p>“Үндэсний бичиг III” хөтөлбөрийн хүрээнд төрийн Ерөнхий боловсролын монгол хэл, уран зохиолын 8 багш 5 байгууллагын 150 албан хаагчдад үндэсний бичгийг заасан. Хичээл сургалтаа эхлэхээс өмнө албан байгууллагуудад мэдээллэж, хөтөлбөрийн зорилго чиглэлийг танилцуулан ажилчдаас унших, бичих чадвараар гараа тогтоож сургалтаа эхлэсэн.</p> <p>Үүнээс анхлан суралцагчдын гараа 30%-тай байна. Үүнээс үүдэж 2 бүлэгт хуваан 7 хоногт нэг нэг удаа орсон.</p> <p>Бүлэг 1: Унших бичих чадвар сайн учир групп чат үүсгэж мэдээлэл болон уншиж, бичих даалгавар байршуулж, хүнд гаргахгүй үгсээ асууж ярилцаж байв. Танхимаар орохдоо зөвхөн хичээнгүй бичиг заалгах сонирхолтой хүмүүс сууж, бичгийн хэвээ сайжруулах зорилгоор суралцсан.</p> <p>Бүлэг 2: Анхлан суралцах шаардлагатай 45 хүнийг хамрууллаа. Эдгээр суралцагч нар 7 хоногийн 3 дахь өдөр бүр 17-19 цагийн хооронд хичээллэв.</p>
ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД							
3.1. Төрийн үйлчилгээ.							

Зорилт: Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй, ёс зүйн алдаа гаргасан албан хаагчдад хариуцлага тооцож, төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	82	Төрийн захиргааны байгууллагат чиг үүргийн шинжилгээ хийж давхардал, хийдлийг арилган бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.	2020 - 2024	ЗДТГазар		Нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээг Өвөрхангай аймгийн ТЗУХэлтэстэй хамтран хийж, энэ хүрээнд ажлын хийдэл, давхардлыг арилгаж, бүтэц, 22 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.	100%
		Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.	2020 - 2024	ЗДТГазар		Албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ, ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчдийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур үзүүлэлт болгон үнэлэн дүгнэж, 6 дугаар сарын 28-ны өдрийн Б/11 дүгээр тушаал, Б/06 дугаар захирамжаар 14 албан хаагчдад үндсэн цалингийн 20-40%-ийн 2,7 сая төгрөгийн урамшуулал олгосон.	100%
	83	Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагат ил тод, нээлттэй болгоно.	2020 - 2024	ЗДТГ		Төрийн албаны сонгон шалгаруулалтанд удирдах албан тушаалтан-3, төрийн захиргааны албан тушаалтан-1 сул орон тооны захиалгыг өгч зарлуулж, сонгон шалгаруулалтанд орж 2 удирдах, гүйцэтгэх 1 албан тушаалтан шалгалтандаа тэнцэж томилогдсон. Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн дарга нарын сонгон шалгаруулалтын захиалгыг өгсөн. 1 төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр гарсан.	100%
	84	Нэг цэгийн үйлчилгээг стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. /ширээ, сандал/	2020 - 2024	ЗДТГазар		Нэг цэгийн үйлчилгээний ширээ, сандалыг шинэчилж, нэг цэгийн үйлчилгээний стандартын тоног төхөөрөмжийн 28,0 сая төгрөгийн тооцооллыг гаргаж УИХ-ын гишүүдэд албан бичгийг хүргүүлсэн. /2022 оны Хөгжлийн төлөвлөгөөнд тусгах/	90%
	85	ЗДТГ-ын барилга шинээр барих.	2020 - 2024	ЗДТГазар		ЗДТГ-ын барилгын их засварын ажил дуусч ашиглалтанд орсон. 70,0 сая төгрөгийн тоног	100%

							төхөөрөмж, тавилгаар тохижилтын ажил хийгдсэн.	
	86	ЗДТГ-ын урд талбайг тохижуулах, машины зогсоол шинээр барих.	2020 - 2024	ЗДТГазар			Хөрөнгө санхүүгээс шалтгаалж, 2022 онд хийгдэхээр төлөвлөгдсөн	
	87	ЗДТГазар үйлчилгээний авто машинтай болох. /8-12 хүний суудалтай/	2020 - 2024	ЗДТГазар			ЗДТГазарт үйлчилгээний машин шийдвэрлүүлэхээр уламжилж, нэн тэргүүнд шийдвэрлэж өгөхөөр болсон. /2022 оны Хөгжлийн төлөвлөгөөнд тусгах/	100%
	88	Дөрвөн машины багтаамжтай граж барих.	2020 - 2024	ЗДТГазар			2022 оны эхэнд зураг төсөв хийлгэхээр төлөвлөсөн. 2022-2023 онд барина. /2022 оны Хөгжлийн төлөвлөгөөнд тусгах/	50%
	89	Шинэ ковштой болох.	2020 - 2024	ЗДТГазар			2022 оны төлөвлөгөөнд тусгуулах саналтай байна.	
	90	Багийн Засаг дарга нарыг компьютер, ширээ сандлаар хангах.	2020 - 2024	ЗДТГазар	16,8	Тоног төхөөрөмжийг шинэчлэх	Багийн Засаг дарга нарыг Орон нутгийн төсвийн 16,8 сая төгрөгийн санхүүжилтээр компьютер, техник хэрэгсэл, сейф, ширээ, сандалаар хангасан. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 48 дугаар тогтоолоор шинээр нэг баг нэмж Улиастай буюу 6 дугаартай болсон.	100%
3.2. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ								
	91	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно.	2020 - 2024	ЗДТГазар			Њóìúí "Íðíí íóðàèéí òàìààèèèèòúí ò°è°àè°á°ò°"-ний дагуу зурган төлөвлөлтийг хийж, 158 иргэний томилгоот нэгжийг томилгоожуулж, үүрэг гүйцэтгэх, дадлага олгох сургалтыг 1 удаа зохион байгуулсан. 2021 оны 09 сарын 15-аас 19-ны хооронд Цэргийн штабтай хамтран 1 нэгжийн 30 үүрэгтнийг 256 дугаар цэргийн анги дээр бэлтгэл сургалтанд хамруулсан.	100%
	92	Ерөнхий боловсролын бүх сургуулиудад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга	2020 - 2024	ЗДТГазар ЕБС			Хүүхэд, залуучуудын дунд цэрэг-эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх сургалт хичээлийг ЕБС-тай хамтран зохион байгуулж байна.	90%

						<p>авч, 125 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч, 41 гомдол мэдээллийг харъяаллын болон хүлээн авахаас татгалзаж, гэмт хэргийн гомдол мэдээллийн 23-д нь эрүүгийн хэрэг үүсгэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.</p> <p>Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 101-ийг илрүүлж, 55 жолоочийн жолоодох эрхийн үнэмлэхийг 1 жилийн хугацаагаар хасаж, жолооч нарыг нийт 22,000,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 41 иргэнийг Хархорин сум дахь сум дундын шүүхээр 7-30 хоног баривчлуулсан байна. Замын хөдөлгөөний журам зөрчсөн 779 иргэнийг 22,978,000 төгрөгний бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Зөрчлийн 2 хэргийн үлдэгдэлтэй байна.</p> <p>Бат-Өлзий суманд 2021 оны 04 дүгээр сарын 23-29-ний өдрийн хооронд “Техникийн улсын үзлэг” тооллого явагдаж нийт 420 тээврийн хэрэгсэл хамрагдаж, 24 мотоциклийг улсын дугаартай болгож, торгууль нөхөн төлүүлэлт нэгдсэн арга хэмжээний хүрээнд 202 иргэний торгуулийн 12.840.000 төгрөгийг нөхөн төлүүлж ажилласан. Торгууль нөхөн төлүүлэлт арга хэмжээний хүрээнд 2021 онд Бат-Өлзий сумын хүү торгуулийн 100100300988 тоот дансанд 44,0 сая төгрөгний торгуулийн нөхөн төлүүлж төвлөрүүлсэн байна.</p> <p>Бат-Өлзий сумын замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклийн жолооч, зорчигчийг хамгаалах малгай хэрэгжүүлэх, хэвшүүлэх зөрчлийг засуулах чиглэлээр нийт 68 удаа 382 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж 302 иргэнийг хамгаалах малгай өмсгөж хэвшүүлэн, зөрчил гаргасан нийт 190 иргэнийг 2,740,000 төгрөгний бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч ажиллаж байна.</p>	
96	Архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний	2020 - 2024	Цагдаагийн тасаг			<p>Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ ар гэртээ агсан согтуу тавьж, гэр бүл, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 22 иргэнийг Хархорин сум дахь сум дундын шүүхээр 7-30 хоног баривчлуулсан.</p> <p>Архидан согтуурсан үедээ өөрийгөө удирдан авч явах чадваргүй болсон 34 иргэнийг ар</p>	90%

		нийгмийн байгууллагуудтай хамтран хүчирхийллээс хамгаалах байр барих.					гэр, асран хамгаалагчидад нь хүлээлгэн өгсөн. Засаг даргын захирамж гаргуулан “Нийтийн эргүүл”-ийн хуваарь гаргуулан иргэдэд хууль сурталчилах, иргэдийг олноор хамруулах ажлыг зохион байгуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл шалгалтыг зохион байгуулж ажиллаж байна.	
	97	Гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	2020 - 2024	Цагдаагийн тасаг			<p>Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлж Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд тавигдсан видео, шторк, бусад мэдээллийг хэрэгжүүлэх талаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>“Алдуул мал” “Хууль бус ан агнуур” “Эко 2021” “Бяцхан зорчигч” “ Улсын дугаар” “Хамгаалах малгай”, “Торгууль нөхөн төлүүлэлт” “Мотоциль” “Байгалиа хамгаалъя” “Гол” “Нуугдмал” “Би мэдээлэгч-1” Би мэдээлэгч-2” “Хичээл эхэллээ” “Буянт мал” “Галт зэвсэг” “Мал мах” нэгдсэн арга хэмжээг хариуцсан сумандаа үр дүнтэй зохион байгуулж ажилласан.</p> <p>Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн хэсгийн албан хаагч нар 12 удаагийн өргөтгөсөн эргүүл шалгалтанд цагийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж тээврийн хэрэгсэлийн тээш, зорчигч нарт үзлэг шалгалтыг хийж ажилласан.</p> <p>Баасан гарагт цаг хэтрүүлэн ажиллаж байсан 8 цэгийн үйл ажиллагааг зогсоож цагийн хуваарийг баримтлан ажиллах талаар сануулж ажилласан.</p> <p>Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий цэгүүдэд Архигүй орчин аяны хүрээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий 42 цэгт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих/ 6.5.11.11.2,113,11.4,11.5,13. / заалт, аймгийн Засаг даргын тоот захирамжаар зөвлөмж боловсруулан хуулийн буланд байршуулж сурталчилсан.</p> <p>Аймгийн засаг даргын захирамж, сумын засаг дарыг захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг түр хориглосны дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 36 хүнсний дэлгүүрийн архи согтууруулах ундааг</p>	100%

						лацдаж, хяналт тавьж ажилласан. Аймгийн засаг даргын захирамжаар “Баасан” гаригт архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосны дагуу тасгийн алба хаагчид өргөтгөсөн эргүүлийн үүрэг хуваарийн дагуу гүйцэтгэж архи согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа тусгай зөвшөөрлтэй дэлгүүрүүдийг хяналт тавьж ажиллахад зөрчил гаргасан 2 дэлгүүрт холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч шүүхээр 500,000 төгрөгөөр торгуулж ажилласан.	
	98	Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавжуулах цогц арга хэмжээ авах.	2020 - 2024	Цагдаагийн тасаг		Өвөрхангай аймаг Бат-Өлзий сумын 1,2,3,4,5,6 дугаар багийн малчдын зөвлөгөөн болсонтой холбогдуулан малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, зөвлөгөөг өгч, хариуцсан баг тус бүрт малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий малчны бүлэг байгуулж, иргэд малчдад малын хулгайн гэмт хэргийн талаар үнэн бодит мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулж мэдээллийг чандлан нууцлах талаар малчдад ойлгуулж мэдээлэл хийж сумын олон дагагчтай цахим хаягуудад гарал үүсэлгүй мал, мах тээвэрлэхэд Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ тооцуулах талаарх мэдээллийг түгээж малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлгийг байршуулан Өвт 5 дугаар багт “Өвт хайрхан” нэртэй 12 хүний бүрэлдэхүүнтэй малчны бүлэг, Сөдтий 2 дугаар баг Билүүт гэх газар “Тархит” гэсэн нэртэй 8 хүний бүрэлдэхүүнтэй малчны бүлэг байгуулан ажилласан.	100%
	99	Цагдаагийн кабон байрны урсгал засварыг хийх.	2020 - 2024	Цагпаагийн тасаг		Цагдаагийн кабон байрыг шинээр барих барилгын зураг хийгдсэн. 2022 онд барилгын ажил эхэлнэ.	70%
Тав.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
	100	Халдварт цар тахлын үед нийгмийн хамгааллын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.	2021	Онцгой комисс		Сумын Онцгой комисс халдварт цар тахлын үед авах арга хэмжээний талаар 27 удаа хуралдаж, тухай бүр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан.	100%

	101	Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана	2021	Сумын Онцгой комисс			Цар тахлын үед нийгмийн халамжийн 9 төрлийн үйлчилгээг цахимаар хүлээн авч үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэж байна. 2021 онд цахимаар 348 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлж ажилласан. Системээр иргэн өөрөө хандаж гаргасан 34 хүсэлтийг шийдвэрлүүлээд байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх дэлгүүрүүдийг кассжуулах ажлыг зохион байгуулж, зорилтот бүлгийн иргэд дурын дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүнээ авах боломжийг бүрдүүлж ажилласан.	100%
	102	Цар тахлын үед түлээ, нүүрс, хүнсний хомсдолд орж болзошгүй иргэдэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч, дэмжлэг тусалцаа үзүүлнэ.	2021	Онцгой комисс			Нийгмийн халамжийн сангаас тэжээн тэтгэх төрүүлсэн үр хүүхэдгүй, ганц бие 6 ахмад настанд түлшний хөнгөлөлт 840000 төгрөг, 80 хувиас дээш хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй 21 иргэнд 2940000 төгрөг, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 24 хүүхдэд 3360000 төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгосон. Б. Доржготов захиралтай "Их Сумт хайрхан" нөхөрлөлөөс 3 өрхөд өвлийн түлшийг бэлтгэж өгсөн.	100%
	103	Түлээ, нүүрс, хүнс, шатахуун зэрэг өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, тараалт, борлуулалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, үнийн өсөлт үүсэхээс сэргийлж ажиллана.	2021	Онцгой комисс			Түлээ, нүүрс, хүнс, шатахуун, эм зэрэг өргөн хэрэглээний барааны үнийг тогтвортой байлгах, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх талаар сумын Засаг даргын захирамж гарган хэрэгжилтийг хянан ажилласан.	90%
	104	Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулна	2021	Онцгой комисс		Аж ахуй нэгжийн тоо 144	Коронавирус гарсантай холбогдуулан нийт 154 аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн талаарх зөвлөгөө, мэдээллийг facebook, group, цахим орчин, мэдээллийн хэрэгслүүдээр тухай бүр нь сурталчилсан.	100%
	105	Отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг	2021	Онцгой комисс			1 малчин өрх Архангай аймагт отроор өвөлжих мэдээлэл ирсэн. Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хүргэн	50%

		хүргэх, мал сүргээ онд оруулах талаар отор хүлээн авагч аймаг, сумдтай хамтран ажиллах замаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хадгална.				ажиллана.	
5.2.“Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.							
	106	Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн хандив тусламжийг шаардлагатай газар, объектуудад хуваарилах ба сумын Засаг даргын нөөц сангийн гамшгаас хамгаалах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2021	Онцгой комисс		Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулахад Засаг даргын нөөцөөс 43,027,220 төгрөгийг зарцуулаад байна.	100%
	107	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, томуугийн вакцинд төрийн албан хаагчид, өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, пост штабт ажиллаж байгаа иргэдийг хамруулна.	2021	ЭМТөв		Томуугийн вакцин насанд хүрэгчдэд хийгдээгүй. /Жирэмсэн 6 эмэгтэйд хийсэн/ - Ковид 19 вакцин: Жирэмсэн нийт хамрагдвал зохих 78, үүнээс: 1тунд 51, 2 тунд 49, 3 тунд 14 Архаг хууч өвчтэй хамрагдвал зохих 44 Үүнээс: 1тунд 44, 2 тунд 32, 3 тунд 18 ХБИ хамрагдвал зохих 140 Үүнээс: 1 тунд 140, 2 тунд 140, 3 тунд 140 65-аас дээш ахмад настан хамрагдвал зохих 153 Үүнээс: 1 тунд 153, 2 тунд 143, 3 тунд 80 Албан байгууллага: ЭМТ: 1 тун 35, 2 тун 35, 3 тун 28 ЕБС,СӨББ: 1 тунд 172, 2 тун 172, 3 тун 72 ЗДТГ: 1 тун 34, 2 тун 34, 3 тун 30 ИТХ: 1 тун 3, 2 тун 3, 3 тун 1 Төрийн банк: 1 тун 8, 2 тун 8, 3 тун 6 Хаан банк: 1 тун 5, 2 тун 5, 3 тун 4	100%

						Цагдаа: 1 тун 5, 2 тун 5, 3 тун 5 ЭЭС: 1 тун 5, 2 тун 5, 3 тун 4	
108	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулна	2021	ЭМТөв ЕБС СӨББ			Сургууль, цэцэрлэгийн 674 хүүхдийг улирлын томуугийн вакцинд хамруулсан. Томуугийн вакцинд: ЕБС-ийн хүүхэд 499 СӨББ-ын хүүхэд 175	100%
109	Халдварт өвчний голomtод ажилласан албан хаагчдад урамшуулал, дэмжлэг олгоно.	2021	ЭМТөв			Халдварт өвчний голomtод ажилласан албан хаагчдад илүү цагийн 52,0 сая тагрөг, 49 ,0 сая төгрөгийн тэтгэмж олгосон.	100%
110	Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд хэрэглэгдэх вирусийн эсрэг эм, сонгомол антибиотик, үрэвслийн эсрэг эм, тариа, оношлуур, хамгаалах хэрэгслэлийн нөөцийг бүрдүүлнэ.	2021	ЭМТөв			Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл: Бээлий 6500 хос, Малгай 3200, маск 5500, N95-3000, комбинзон 350, нэг удаагийн халад 2850, Нүүрний хаалт 3000, Оношлуур 950, Антибиотик, вирусын эсрэг эм: Азитромицин 500 мг-120 таб, Ацикловир 200 мг-5680 таб, Анаферон –920 Эргоферон -800 Цефатоксим 400 фл, АЦЦ 200 мг-1780 пач Нөөцийг бүрдүүлсэн.	100%
111	Тархвар судлал, халдварт, зоонозын халдварт өвчний чиглэлээр эмч мэргэжилтнийг бэлтгэх, сургаж, чадавхжуулах, орон тоог нэмэгдүүлнэ.	2021	ЭМТөв			ЭМГазраас шинэ эмнэлэг баригдахаар орон тооны асуудал шийдэгдэнэ.	50 %
112	Сумын Эрүүл мэндийн төвийн халдвартын тасгийг өргөжүүлж, байрны асуудлыг шийдвэрлэнэ.	2021	Онцгой комисс ЭМТөв			ЭМТөвийн хуучин байрыг ковидын эмнэлгээр 58 орыг дэлгэн үйл ажиллагаагаа явуулж байна.	90%
113	Цар тахлын үед ажиллах тусгаарлах болон тусгаарлан ажиглах байрыг томилгоожуулж,	2021	Онцгой комисс			2021 оны 06 дугаар сараас 08 дугаар сарыг дуустал хугацаанд ЕБС-ын 100 хүүхдийн дотооур байрыг	100%

		бэлэн байдлыг хангана.				Тусгаарлан ажиглах байраар ашиглаж үйл ажиллагаа явуулж байсан. Мөн Тусгаарлан ажиглах байрны нөөцөнд 2 зочид буудлыг эрэмбэлж хариуцсан эзэдтэй гэрээ хийж бэлтгэсэн	
	114	Халдварт хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах орчин үеийн дэвшилтэт технологит суурилсан байгууламжийг бэлэн болгоно	2021	Онцгой комисс		Ковидоос гарсан хог хаягдлыг тусгай өнгийн (Шар) уутанд савлаж хог түр хадгалах байранд хадгалж халдваргүйжүүлэлт хийсний дараа төвлөрсөн хогийн цэгт асгаж устгал хийдэг	100%
	115	Хорио цээрийн дэглэмийн үед хэмнэгдсэн зардлыг тооцож, нэн шаардлагатай арга хэмжээнд сумын Онцгой комиссын шийдвэрийг үндэслэж, зарцуулна.	2021	Онцгой комисс		Онцгой комиссоос ЭМТөвөөс тусгаарлах эмнэлэг болон ажиглах байранд ажиллаж байсан эмч, сувилагч нарын халад, малгай, нүүргэвч, бээлий авахад 242,5 мян,төгрөг, түргэн тусламжийн 2 автомашины засварын зардалд 6,286,5 мян,төгрөг, тусгаарлан ажиглах байранд хэвтэн эмчлүүлэгч нарын мах, хоол, хүнсний зардалд 13,812,450 төгрөг, ахуй хэрэглээний зардалд 1,918,950 төгрөг, хүчилтөрөгчийн баллон /10 л-ийн/ - 2 ш 1,000,0 төгрөг, ЭМТөвийн халаалтгүй өрөөг халаалттай болгох засварт 500,0 төгрөг,тусгаарлах эмнэлэгт угаалгын машин 350,0 төгрөг, 1 иргэн 1 шинжилгээний 800 сорьцны үнэ 10,000,0 төгрөг, нийт 34,110,400 төгрөгийг Засаг даргын нөөцөөс гарган шийдвэрлэсэн. ЕБСургууль, 1, 2 дугаар цэцэрлэг, ЗДТГазарт мананцар үүсгэгч тус бүр 1 ш-ийг, нийт 1,400,0 мян, төгрөгөөр Засаг даргын нөөцөөс авч өгсөн	100%
	116	Сурагчдад цахимаар явуулах хичээлийн цагийг зохистой хэмжээнд хүргэхийн зэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн хоцрогдол гаргахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2021	ЕБС		Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/292, А/525 дугаар “Түр журам батлах тухай” тушаалыг мөрдөж цар тахлын халдварын тархалтаас хамаарч танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хичээл сургалтыг зохион байгуулж байна. Зайн сургалтын хуваарь гарган 6-12 ангийн сурагчдад “google meet8” zoom апплейшин ашиглан хичээлээ зааж байна.Мөн теле хичээлийн хуваарийг сурагчдад хүргэж дасгал даалгаварыг хянан эргэх холбоотой	100%

							ажиллаж байна.	
	117	Сургууль, цэцэрлэг бүр цахим, теле хичээл бэлтгэн, технологийн сан бүрдүүлж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж, танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин, тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна.	2021	ЕБС СӨББ			Багш бүр medlee.mn –д байршсан хичээлүүдийг татан авч теле хичээлийн сан бүрдүүлж ажиллаж байна. БМДИ-ээс зохион байгуулсан “Хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх нь” сургалтад 3 багш оролцож ирээд багш нартаа сургалт зохион байгуулсан. Цахим хичээлд шилжих хугацаанд дунд ахлах ангийн багш нар цахим хичээл бэлтгэн зааж байна.	90%

ᠲᠢᠶ᠋ᠭᠠᠭᠤ /᠔᠓ᠢ ᠵᠴᠢᠵᠡᠭᠡ᠔ᠦᠭᠦᠳᠦ/

Ä/ä	Àæèè ᠵᠡᠡᠰᠡᠭᠡᠭᠡᠳᠡ ᠔᠓ᠢ	᠔᠔äü	Äᠵi
1.1	7	91,6	
1.2	19	92,0	
1.3	9	95,0	
1.4	7	98,0	
1.5	4	98,0	
2.1	10	92,5	
2.2	8	87,4	
2.3	17	90,4	
3.1	10	91,0	
3.2	4	92,0	
4.1	5	94,0	
5.1	6	98,0	
5.2	12	98,1	

Ájáä	117	94,0	
------	-----	------	--